



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 503

Улаанбаатар хот

Нууцын жагсаалт батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Байгууллагын нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны нууц баримт бичгийн жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Санхүүгийн зохицуулах хорооны төрийн болон байгууллагын нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан жагсаалтыг нууц баримт бичгийг боловсруулах, хадгалж хамгаалах, ашиглах үйл ажиллагаанд чанд мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Тушаал батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 265 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд хамаарах нууцын журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн
03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УХА0410 5043239

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|-----|--|
| 1. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүртгэлийн дэвтэр |
| 2. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 3. | Албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, бусад тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн шалгасан, устгасан тухай мэдээ, акт баримт бичиг |
| 4. | Хорооны даргаас дотоод мэдээлэл гэж тогтоосон бүх төрлийн мэдээ, мэдээлэл |
| 5. | Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлдэж байгаа танилцуулга, судалгаа, шийдвэрийн төсөл |
| 6. | Хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл |
| 7. | Хорооноос хийсэн Зөрчлийн хэрэг бүртгэлтийн материалыас бусад хяналт, шалгалтын баримт бичгүүд |
| 8. | Зөрчлийн хэрэг бүртгэлт, хяналт, шалгалтын явцын талаарх мэдээлэл |
| 9. | Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцох гэж байгаа болон оролцож байгаа гадаад, дотоодын аж ахуйн нэгж, хувь хүний Хороонд ирүүлсэн эд хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмж, технологийн шийдэл, тэдгээрийн хоорондын харилцаанд холбогдох мэдээ, баримт бичиг, дотоод мэдээлэл |
| 10. | Санхүүгийн зах зээлийн дотоод мэдээлэл, судалгаа, эзэмшигчийн бүртгэлтэй холбоотой баримт, мэдээлэл олон нийтэд мэдээлэх Хорооны даргын шийдвэр гарах хүртэл |
| 11. | Харилцагч байгууллагаас ирүүлсэн санхүүгийн зах зээлийн дотоод мэдээлэлд хамрагдах нууц материал |
| 12. | Санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа болон Хувьцаат компанийн хувьцааны багцын 1 хуртэлх хувийг эзэмшигчдийн нэрс |
| 13. | Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны улс, хот хоорондын холбоо, мэдээлэл дамжуулах тогтолцоо |
| 14. | Дотоод хяналт, шалгалт, аудитын болон ёс зүйн хорооны шалгалтын явцын мэдээлэл |

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2017 оны ... дүгээр сарын ...-ний өдрийн
503 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УХА0410 5043239

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД
“ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦ БАРИМТ
БИЧИГТЭЙ ТАНИЛЦАХ ЭРХ БУХИЙ АЛБАН
ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ”**

1. Хорооны дарга
2. Дэд дарга /Орон тооны гишүүн/
3. Ажлын албаны дарга
4. Хорооны газрын дарга, газрын орлогч дарга, хэлтэс, албаны дарга нар
5. Хорооны бусад албан хаагч /зөвхөн өөрсдийн албан ажилтай холбоотой баримт бичигтэй Хорооны дарга болон Ажлын албаны даргын зөвшөөрлөөр/
6. Хорооны нууцын ажилтан